



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/349

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2012 оны 19 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” 2010 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 394 дүгээр тушаалын Сүхбалт овогтой Нандинтуяатай холбогдох хэсгийн “2 жилийн” гэснийг “3 жилийн” гэж, “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2011 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 279 дүгээр тушаалын Зөвөө овогтой Энхболдтой холбогдох хэсгийн “Сангийн яамны захиалгаар АНУ-ын Кальфорний олон улсын их сургуулийн магистрантурт Олон улсын гаалийн эрх зүйн чиглэлээр” гэснийг “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын захиалгаар Австрали Улсын Сентрал Квинслэнд их сургуулийн магистрантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР - Г.

D:\tushaal\STS-2012

9000205